



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

### Эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хаан даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Жадамба овогтой Баярсайханыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Эрдэнэбат овогтой Энхзулыг, гүйцэтгэх захирлаар Мөнхбаатар овогтой Одыг тус тус томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллахыг Ж.Баярсайхан, Э.Энхзул, М.Од нарт үүрэг болгосугай.
3. Тогтоол батлагдсантай холбоотой 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 307 тоот тушаал, 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 518 тоот тушаал, 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 361 тоот тушаалын Гончиг овогтой Энхбилэг, Дорлиг овогтой Алтанчимэг нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН